



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 550

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа, үнийг шинэчлэн
тогтоож балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын харьяа Хэнтий аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй

2.Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Хэнтий аймгийн Татварын хэлтсийн дарга А.Гантөмөр, “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Түвшинмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006906

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны
өдрийн 550 дугаар тогтоолын хавсралт

Хэнтий аймгийн Татварын хэлтсийн балансаас "Талын зам" ТӨХК-д
балансад шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо шир хэг	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа
1	Приус 20 маркийн, 34-50 ХЭҮ улсын дугаартай, суудлын автомашин, арлын дугаар- NHW203247914	2007/2015	1	15,000,000.00	3,750,000.00	2
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)	15,000,000.00 (арван таван сая)	3,750,000.00 (гурван сая долоон зуун тавин мянга)	